

Газрын тосны ашиглалтын хэлтэс
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь		
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	Өөрийн үнэлгээ	ХШҮ	
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ	Үйл ажиллагааны зардал	Олборлолтын хэмжээ	4.7 сая баррель буюу 645.5 мянган тонн	4.85 сая баррель буюу 659.2 мянган тонн	2024 онд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайнуудаас 4.85 сая баррель буюу 659.2 мянган тонн газрын тос олборлох төлөвлөгөөтэй байгаагаас хүлээгдэж буй гүйцэтгэлээр	98%	90%	

					<p>2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4.19 сая баррель буюу 562.6 мянган тонн газрын тос олборлож, төлөвлөгөөний биелэлт 85.0 хувь байхаар байна. Газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2024 онд Тамсаг XXI талбайд хэвтээ 5 цооног ерөмдөж шингэн хагалбар перфораци хийх, 5 босоо цооног ерөмдөх, 10 хуучин цооногт шингэн хагалбар, Тосон Уул XIX талбайд цооногийн</p>		
--	--	--	--	--	--	--	--

						<p>мөргөцгийн хажуу өрөмдлөг 5 цооног, хуучин 5 цооногт том хэмжээний шингэн хагалбар хийх, 1997 оны БХГ-т талбайд 5 цооног шинээр өрөмдөж перфораци, шингэн хагалбар хийх, 10 хуучин цооног сэргээн ашиглалтад оруулах ажлын төсөв, төлөвлөгөө батлагдсан. Матад ХХ талбайг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 256 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан бөгөөд 2024 оны 05</p>	
--	--	--	--	--	--	--	--

					<p>дугаар сарын 27-ны өдөр Матад сумын засаг даргын А/76 тоот тушаалаар Матад суманд газар ашиглах захирамж олгосноор Дорнод аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт ажил гүйцэтгэх А даалгаврын хүсэлтийг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр цахимаар хүргүүлснээр олборлолтын үйл ажиллагааг явуулах нөхцөл бүрдэж 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Цэнтогоруу цооногийн олборлолтыг эхлүүлсэн.</p>	
--	--	--	--	--	--	--

Өнөөдрийн байдлаар хоногт 200 орчим баррель газрын тос олборлон, экспортлож байна. Тус онд газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Тосон-Уул XIX талбайд 5 цооног, Тамсаг XXI талбайд 7 цооног, БХГ-97 талбайд 2 цооног тус тус шинээр өрөмдсөн болно. Газрын тосны олборлолтын үйл ажиллагааг эсэргүүцэн талбай дээр жагсаал цуглаан зохион байгуулсан этгээдүүдийн хувьд Тагнуулын

						Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газруудад дэмжлэг хүссэн албан бичиг хүргүүлж, мөрдөн байцаах үйл ажиллагааг эхлүүлсэн.			
1.1.1	Олборлож буй тосны тоо хэмжээнд газар дээр нь хяналт тавих.	Үйл ажиллагааны зардлаар	Олборлолтын хэмжээн	4.7 сая баррель буюу 645.5 мянган тонн	1.82 сая баррель буюу 247.3 мянган тонн	4.85 сая баррель буюу 659.2 мянган тонн	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын баталсан Томилолтын удирдамжийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн Газрын тосны ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд Дорнод аймгийн Матад сумын нутаг орших Тосон-Уул XIX, Халхгол сумын нутаг орших Тамсаг XXI талбай, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг орших Бүтээгдэхүүн	85%	90%

						<p>хуваах гэрээт 1997 оны талбайнуудад албан томилолтоор 328 хоног ажилласан. Томилолтоор ажиллах хугацаандаа тус талбайнуудаас олборлож буй газрын тосны тоо хэмжээнд өдөр бүр хяналт тавьж, бүртгэл хөтлөн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. Петрочайна дачин тамсаг ХХК нь Тосон-Уул XIX талбайд олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан нийт 486 цооног байгаа бөгөөд үүнээс нэгдсэн байгууламжид холбогдсон 400 цооног, холбогдоогүй 86 цооногоор хоногт дунджаар 4574 баррель, задгайгаар буюу цооног шавхалтад ашиглаж буй 364 цооног байгаагаас 72 цооногоор</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

						<p>хоногт дунджаар 547 баррель, нийт 5121 баррель газрын тосыг хоногт олборлож байна. Тамсаг ХХИ талбайгаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан 307 цооногоос 1,819,464 баррель, задгайгаар буюу цооног шавхалтаар 189,089 баррель, нийт 2,008,553 баррель буюу 270,399 тонн газрын тос олборлосон байна. Доншен Газрын тос (Монгол) ХХК нь БХГ-т 1997 оны талбайгаас 2024 онд 424,637 баррель буюу 59,390.0 тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

							олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан цооногуудаас 312,898 баррель буюу 43,762 тонн газрын тос олборлосон. 1997 оны БХГ-т талбайд олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан нийт 188 цооног байгаа бөгөөд үүнээс дунджаар 138 цооногоор хоногт дунджаар 1070 баррель олборлож байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр Монгол Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4.19 сая баррель буюу 562.6 мянган тонн тос олборлохоор байна.		
1.1.2	Экспортолж буй тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээнд газар дээр нь байнгын хяналт тавьж ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Экспортын тоо хэмжээ	4.6 сая баррель буюу 622.8 мянган тонн	1.82 сая баррель буюу 247.3 мянган тонн	4.85 сая баррель буюу 659.2 мянган тонн	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын баталсан Томилолтын удирдамжийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 08-	84%	70%

							<p>ны өдрөөс эхлэн Газрын тосны ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Тосон-Уул XIX, Халхгол сумын нутагт орших Тамсаг XXI талбай, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт орших Бүтээгдэхүүн хуваах гэрээт 1997 оны талбайнуудад албан томилолтоор 143 хоног ажилласан. Томилолтоор ажиллах хугацаандаа тус талбайнуудаас экспортолж буй газрын тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээнд тухай бүрд хяналт тавьж, бүртгэл хөтлөн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. Тосон-Уул XIX талбайгаас 2024 оны 05 дугаар сарын 31-ний</p>		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						<p>байдлаар нийт 762,155 баррель буюу 101,135 тонн газрын тосыг БНХАУ руу экспортлоод байна. Өдөрт дунджаар 20 автоцистернээр 5,210 баррель тосыг БНХАУ-д экспортолж байна. Экспортолж буй газрын тосны усны агуулга 0.03 хувь, дундаж нягт 835.2 кг/м3 байна. Тамсаг XXI талбайгаас 2024 оны 12 дугаар сарын 03-ны байдлаар нийт 7,300 автоцистернээр 1,959,152 баррель буюу 270,582 тонн газрын тосыг БНХАУ руу экспортлоод байна. Өдөрт дунджаар 20 автоцистернээр 5,545 баррель тосыг БНХАУ-д экспортолж байна. Экспортолж буй газрын тосны усны агуулга 0.05 хувь, дундаж нягт 865.4</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

						<p>кг/м3 байна. БХГ-97 талбайгаас 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар 333,191 баррель буюу 49,652 тонн газрын тосыг БНХАУ-д экспортолсон байна.</p> <p>Экспортолсон тосны усны агууламж 0.025 хувь, 15 градус дахь нягт 884.6 кг/м3 байсан. Мөн экспортолж буй газрын тосны мэдээг өдөр бүр нэгтгэж 7 хоног бүрийн баасан гаригт ГТАХ-т цахимаар мэдээ хүргүүлж, шаардлагатай үед удирдлагатай утсаар холбоогдож мэдээ, мэдээллээр хангаж, чиглэл авч ажилласан.</p> <p>Монгол Улсын хэмжээнд нийт хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 4.09 сая баррель</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

							буюу 555.6 мянган тонн тос экспортлохоор байна.		
1.1.3	Экспортолж буй тосны чанарын шинжилгээ, ачилт, буулгалтын тоо хэмжээнд хяналт тавьж бүртгэл хөтлөх.	Үйл ажиллаг ааны зардлаар	Пүүг хянан шалгасан тоо хэмжээ	24	12	24	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын баталсан Томилолтын удирдамжийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн Газрын тосны ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд Дорнод аймгийн Матад сумын нутаг орших Тосон-Уул XIX, Халхгол сумын нутаг орших Тамсаг XXI талбай, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг орших Бүтээгдэхүүн хуваах гэрээт 1997 оны талбайнуудад албан томилолтоор 328 хоног ажилласан. Томилолтоор ажиллах хугацаандаа тус талбайнуудаас	100%	100%

						<p>экспортолж буй газрын тосны буулгалтын тоо хэмжээ, чанарын шинжилгээнд өдөр бүр хяналт тавьж, бүртгэл хөтлөн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн нэгдсэн байгууламж дах хэмжих хэрэгслийг нийт 25 удаа шалгасан. Олборлолтын ил байгууламжаас экспортолж буй түүхий тосны хэмжилтийг гүйцэтгэдэг авто машины пүүний хэвийн ажиллагааг шалгах ажлыг 14 хоногт 1 удаа шалгах хувиарын дагуу зохион байгуулсан. Гаалийн хяналтын пүү болон дотоодын тээвэрлэлтэд ашиглаж байгаа пүүнүүдийг шалгахад 20 кг зөрүү үүссэн бөгөөд пүүнүүдийг цаг тухайд нь</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							<p>тохируулж баталгаажуулсан бөгөөд MNS 5311:2003 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнд байсан. БХГ-97 талбайгаас 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 40 удаагийн ачилтаар 333,191 баррель буюу 49,652 тонн газрын тосыг БНХАУ-д экспортолсон байна. Экспортолсон тосны усны агууламж 0.025 хувь, 15 градус дахь нягт 884.6 кг/м3 байсан.</p>		
1.1.4	<p>Гэрээлэгчдийн гадаад ажиллах хүч, мэргэжилтэн Монгол улсад хөдөлмөр эрхлэхтэй холбоотой асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх эд дэмжлэг</p>	<p>Үйл ажиллагааны зардал</p>	<p>Гаргасан тодорхойл олтын тоо</p>	3	-	3	<p>“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-аас гадаад ажиллах хүч, мэргэжилтэнүүдий нхээ 2024 оны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг сунгуулах 410 хүн, 2025 онд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах 891 хүний</p>	100%	90%

	үзүүлэх.						<p>хүсэлтийг манай газарт ирүүлсэн. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-аас ирүүлсэн хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг сунгуулах шинээр хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан иргэдийн материалыг судалж үзээд Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.17 дах заалт, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дах заалтыг тус тус үндэслэн уг ажлын байруудад Монгол Улсын иргэн-мэргэжилтэн, мэргэжлийн ажилчдыг ажилд авах, сургах, дадлагажуулах бүрэн боломжтой 13 гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг сунгах шаардлагагүй гэж</p>		
--	----------	--	--	--	--	--	---	--	--

						<p>үзсэн бөгөөд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 2024-2025 онд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл сунгах 397, 2025 онд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох 891, нийт 1288 гадаад ажиллах хүч, мэргэжилтнүүдийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгах, олгох асуудлыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд уламжилсан. Мөн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн гадаад ажиллах хүчний зөвшөөрлийг сунгуулах хүсэлт ирсэн ба өнөөдрийн байдлаар судлах ажлыг гүйцэтгэж байна. 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс өмнө АҮЭБЯнд тодорхойлолтыг</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

							хүргүүлэх болно		
1.1.5	Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, бодлогын баримт бичиг, нээлттэй өгөгдлийн мэдээ мэдээлэл, хэлтсийн төлөвлөгөө, тайланг тухай бүр боловсруулж, холбогдох газар, хэлтэст хүргүүлэх.	Үйл ажиллаг ааны зардал	Гаргасан тайлан, мэдээллийн тоо	12	6	12	Газрын тосны салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх санал боловсруулж Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн нарт албан бичгээр хүргүүлсэн. Мөн газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд хууль бусаар саад учруулж буй төрийн бус байгууллага, иргэдийн тухай мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр-д	100%	100%

						<p>хүргүүлсэн. Бүтээгдэхүүн хуваах гэрээт Матад ХХ талбайд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа эхлүүлэх арга хэмжээ авч ажиллах мэдэгдлийг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд албан бичгээр илгээсэн. Мөн УУХҮСайдаас Матад ХХ ашиглалтын талбайг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг орон нутгийн удирдлагас дэмжихгүй байгаа асуудлыг уламжилж, дэмжлэг хүссэн. Түүнчлэн Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газар, гэрээлэгч компаниудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг боловсруулж,</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

							<p>тухай бүрд нь хариу хүргүүлсэн. Төрийн бүтээмжийн үндэсний хороо, Цахим хөгжил, харилцаа, холбооны яам, Үндэсний статистикийн хорооны ажлын хэсгийн хүрээнд Мета өгөгдлийн цахим платформ байгуулахаар төлөвлөн ажиллаж байгаатай холбогдуулан авч буй өгөгдлийн судалгаанд Газрын тосны ашиглалтын хэлтэст байгаа өгөгдлийн мэдээллийг оруулав. Мөн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн Д/04 дугаар Нээлттэй мэдээллийг нийтлэж байх тухай албан даалгаврын дагуу Газрын тосны ашиглалтын</p>		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							хэлтсээс гарах мэдээллийг тайлбартай хамт бэлтгэж, хариуцсан ажилтанд цахимаар хүргүүлсэн. Мөн Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024 он)-ийн хэрэгжилтийг гарган ТЗУГ-ын холбогдох ажилтанд хүргүүлэв		
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.1.	Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах.	Үйл ажиллагааны зардал	Гаргасан гэрээний хэрэгжилтийн тоо	4	4	2024 онд Тосон Уул XIX талбай 104.4 сая ам.доллар, Тамсаг XXI талбай 135.8 сая ам.доллар, Матад XX талбай 15.2 сая ам.доллар, 1997 оны бүтээгдэхүүн	95%	90%	

					<p>хуваах гэрээт талбай 31.3 сая ам.долларын хөрөнгө оруулалтын ажил хийхээр ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулсан. Бүтээгдэхүүн хуваах гэрээт газрын тосны ашиглалтын талбайнуудын 2024 оны батлагдсан ажлын төлөвлөгөө, төсөв 286.4 сая ам.доллар байгаа нь 2023 оны батлагдсан ажлын төлөвлөгөө, төсвөөс 1.3 дахин бага байна. Энэ нь газрын тосны олборлолт, экспортын үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын шууд болон</p>		
--	--	--	--	--	--	--	--

					<p>шууд бус нөлөөлөл, хууль эрх зүйн орчны тогтвортой бус байгаатай холбоотой байна. Петрочайна дачин тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбай, Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 1997 оны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн БХГ-г Газрын тосны тухай хууль, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 199 дүгээр захирамжаар</p>		
--	--	--	--	--	--	--	--

					<p>“Гэрээлэгч хоёр компанитай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх хэлэлцээ хийх Монголын талын ажлын хэсэг” байгуулагдсан. Уг ажлын хэсэг болон УУХҮЯ-г мэдээллээр ханган ажилласан. Үүний дараа тухайн ажлын хэсгийг дахин шинэчлэж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 30 дугаар захирамжаар “Петрочайна дачин тамсаг ХХК болон</p>		
--	--	--	--	--	--	--	--

						<p>Доншен Газрын тос (Монгол) ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх хэлэлцээ хийх Монголын талын ажлын хэсэг” байгуулагдсан. Тус ажлын хэсэгт шаардлагатай мэдээлэл, тооцоолол, тайлбар зэргийг хүргүүлсэн. Мөн гэрээ шинэчлэх асуудлын талаарх санал, дүгнэлтээ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн.</p>			
3.1.1	Тосон-Уул XIX,	Үйл	Төлөвлөгө	4	4	4	Ашигт малтмал,	100%	100

	Тамсаг XXI, 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн 2023 оны ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг гэрээлэгчтэй тулган баталгаажуулах	ажиллаг ааны зардал	ө, төсвийн гүйцэтгэлийн тоо хэмжээ				газрын тосны газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн 2023 оны ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр дүгнэж баталгаажуулсан. “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн 2023 оны ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр гэрээлэгчтэй хэлэлцэн дүгнэж баталгаажуулсан.		%
3.1.2	Тосон-Уул XIX,	Үйл	Бүтээгдэхү	4	4	4	Ашигт малтмал,	100%	100

	<p>Матад XX, Тамсаг XXI, 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 2023 оны хэрэгжилтийн тайланг гэрээлэгчидтэй хэлэлцэн дүгнэх.</p>	<p>ажиллаг ааны зардал</p>	<p>үн хуваах гэрээний хэрэгжилти йн тоо</p>				<p>газрын тосны газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 09- ний өдрийн А/04 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Тосон- Уул XIX, Тамсаг XXI талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 2023 оны хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр дүгнэж баталгаажуулсан. “Доншен газрын тос (Монгол)” ХХК- ийн 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн 2023 оны гэрээний хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр гэрээлэгчтэй хэлэлцэн дүгнэж баталгаажуулсан. Харин Петроматад ХХК-ийн Матад XX талбайн</p>		<p>%</p>
--	---	------------------------------------	---	--	--	--	--	--	----------

							бүтээгдэхүүн хуваах гэрээний 2023 оны хэрэгжилтийг 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр дүгнэсэн.		
3.1.3	Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайгаас 2023 онд олборлосон шингэн, үүнээс ус, тос, хийн хэмжээ, экспортолсон тосны тоо хэмжээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигласан усны хэмжээг гэрээлэгчидтэй тулган баталгаажуулах.	Үйл ажиллагааны зардал	Байгуулсан протоколын тоо хэмжээ	3	3	3	Тосон-Уул XIX, Тамсаг XXI бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайгаас 2023 онд олборлосон шингэн, үүнээс ус, тос, хийн хэмжээ, экспортолсон тосны тоо хэмжээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигласан усны хэмжээг гаргаж, гэрээлэгчидтэй тулган баталгаажуулахаар ажиллаж байна. 1997 оны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн Зүүнбаян, Цагаан-Элсний ордоос 2023 онд олборлож, экспортолсон түүхий тосны тооцоог “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн холбогдох	100%	100%

							<p>ажилтантай хамтран гүйцэтгэж, эцэслэсэн болно. Эцсийн байдлаар гаргасан тооцог гэрээлэгчийн компанид хүргүүлсэн ба 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус компанийн удирдлага хянах ажлыг гүйцэтгэж байна. 2023 оны түүхий тосны олборлолт, экспортын тооцоог хийж үзэхэд нийт 403,106 баррель буюу 56,378 тонн түүхий тос олборлож, 426,855 баррель буюу 59,938 тонн түүхий тос экспортлож, танк фарм болон хадгалах савын үлдэгдэл оны эхэнд 43,682 баррель, 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 16,674.0 баррель болж, олборлолт, экспортын зөрүү 7357.04 баррель буюу нийт орлогын</p>		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							1.49% байна. Тамсаг XXI талбайгаас 2023 онд олборлосон шингэн, үүнээс ус, тос, хийн хэмжээ, экспортолсон тосны тоо хэмжээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигласан усны хэмжээг гэрээлэгчидтэй 2024 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр тулган баталгаажуулсан.		
3.1.4	Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдээс ирүүлсэн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг судалж, санал дүгнэлт гаргаж, батлуулах	Үйл ажиллагааны зардал	Ажлын төлөвлөгөө, төсвийн тоо хэмжээ	4	4	4	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж 2024 оны ажлын төлөвлөгөө, төсвийн төсөлд санал дүгнэлт өгч, “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн 2024 оны ажлын төлөвлөгөө,	100%	100%

							<p>төсвийг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлуулсан.</p> <p>“Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн 2024 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр батлуулсан.</p> <p>Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайн 2024 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр батлуулсан.</p>		
3.1.5	Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний нэмэлт тодотголын төслийг судалж гэрээлэгчид зөвлөмж хүргүүлэх.	Үйл ажиллагааны зардал	Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний нэмэлт тодотголд гаргасан санал дүгнэлтийн тоо	2	-	2	Петрожайна дачин тамсаг ХХК-ийн зүгээс Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний нэмэлт тодотголын төсөлд өөрчлөлт оруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх	100%	100%

						<p>зорилгоор Монгол хэл рүү хөрвүүлэх ажлыг гүйцэтгэж, нэмэлт тодотголын төслийг 2023 оны 12 дугаар сарын 24-ний өдөр АМГТГ-т ирүүлсэн. Гэвч тус төсөл нь 2012 онд батлагдсан төлөвлөгөөний үзүүлэлтүүдээс хэт зөрүүтэй байсан тул баталгаажуулах боломжгүй байсан. Үүнтэй холбогдуулан эхний ээлжинд Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордын нөөцийн тооцооны тайлангийн тодотгол, дахин тооцооллын ажлыг гүйцэтгэхээр болсон. Газрын тосны орд ашиглах төлөвлөгөө нь батлагдсан нөөцийн үндсэн дээр хийгддэг тул эхлээд тус ордуудын нөөцийн тооцооны тайлангийн тодотгол, дахин</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

						<p>тооцоолол гүйцэтгэх нь зүйтэй гэж үзсэн. Петровича дачин тамсаг ХХК нь БНХАУ-ын Апекс резервойр компанитай гэрээ байгуулж, Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордын нөөцийн тооцооны тайлангийн тодотгол, дахин тооцоолол хийх ажлыг Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага журмын дагуу гүйцэтгэж байна. Өнөөдрийн байдлаар Петровича дачин тамсаг ХХК-ийн толгой компани болох БНХАУ-ын Үндэсний газрын тос, хийн хайгуул, ашиглалтын корпорациар хянуулах ажлыг гүйгэтгэж байгаа талаар гэрээлэгчтэй хийсэн уулзалт болон албан</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

							бичгээр мэдэгдсэн болно.		
3.1.6	Гэрээлэгчээс ирүүлсэн Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян, Цагаан-Элсний газрын тосны ордын нөөцийн хөдөлгөөний 2022 оны тайланг хянаж, санал дүгнэлт гаргах.	Үйл ажиллагааны зардал	Хянасан тайлангийн тоо	3	-	3	Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын дагуу “Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” журмыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/287 дугаар тушаалаар баталсан. Үүний дагуу Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордын нөөцийн тооцооны тайлангийн тодотгол, дахин тооцооллын ажлыг гүйцэтгэж байна. Өнөөдрийн байдлаар Петрочайна дачин тамсаг ХХК-ийн толгой компани болох БНХАУ-ын Газрын тос, хийн хайгуул, ашиглалтын үндсэн	100%	90%

						<p>корпорациар хянуулах ажлыг гүйцэтгэж байна. Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн хувьд Зүүнбаян, Цагаан-Элсний ордын газрын тосны нөөцийн дахин тооцооллын тайлангийн төслийг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 34/24 дугаар албан бичгээр ирүүлсэн ба тухайн тайланг засаж, сайжруулах талаар саналаа гэрээлэгчид хүргүүлсэн. Газрын тосны ашиглалтын жилийн тайлан, нөөцийн хөдөлгөөний тайланг Доншен газрын тос (Монгол) ХХК нь 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр 02/24, Петрожайна дачин тамсаг ХХК нь 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 24/3-</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							421 дугаар албан бичгээр ирүүлсэн ба тухайн тайлангуудыг хүлээж авсан.		
3.1.7	Газрын тосны ашиглалтын талбайнуудад 2023 онд хийж гүйцэтгэх ажлуудын мэдээг АМГТГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний А/17 дугаар тушаалаар баталсан мэдээний загварын дагуу хүлээн авч, хянан үзэх, бүртгэл хөтлөх, гүйцэтгэлд хяналт тавих.	Үйл ажиллаг ааны зардал	Албан томилолто ор ажилласан хоног	365	120	240	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын баталсан Томилолтын удирдамжийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн Газрын тосны ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Тосон-Уул XIX, Халхгол сумын нутагт орших Тамсаг XXI талбай, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт орших Бүтээгдэхүүн хуваах гэрээт 1997 оны талбайнуудад албан томилолтоор 328 хоног ажилласан. Томилолтоор ажиллах тус хугацаандаа тус	100%	100 %

						<p>талбайд хийгдэж буй цооног үйлчилгээний болон ашиглалтын цооногийн хэмжилт, туршилтын үйл ажиллагаанд газар дээр нь хяналт тавьж, АМГТГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/17 тушаалаар баталсан мэдээний загварын дагуу хүлээн авч, бүртгэл хөтөлсөн. 1997 оны БХГ-т талбайд 2024 оны 12 дугаар сард 20 хоног талбай дээр ажиллах төлөвлөгөөтэй байна. 1997 оны БХГ-т талбайд 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 80 цооногт шахуурга шалгах засвар үйлчилгээ, 8 цооногт шингэн хагалбар үйл ажиллагаа, 10 хуучин цооногийн сэргээн</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							<p>ашиглалтад оруулах, 21 цооногийн гадаргуйн байгууламжийг барьж байгуулах, 1 цооногт азот шахах ажлуудыг гүйцэтгэсэн. Тосон-Уул XIX талбайд 11 төрлийн 1178 удаагийн газрын тосны олборлолтын хэмжилт туршилтын ажил гүйцэтгэсэн байна. 5 цооногт, 144 метрт перфорацийн ажил, 9 цооног 24 үед шингэн хагалбар, 7 төрлийн 238 удаагийн цооногийн засвар үйлчилгээний ажлыг гүйцэтгэсэн</p>		
3.1.8	Тосон-Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны БХГ-т талбайд 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын анхдагч мэдээ, материалыг	Үйл ажиллаг ааны зардал	Нэгтгэж гаргасан ботийн тоо	36	18	36	Уул уурхайн сайдын 2015 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 49 дугаар тушаалаар батлагдсан "Газрын тос, уламжлалт бус газрын тосны	100%	90%

	нэгтгэн боловсруулах						эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавигдах шаардлага" журмын дагуу Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд 2023 онд гүйцэтгэсэн 17 судалгааны ажлын тайлан, 2023 онд хийгдсэн цооногийн шингэн хагалбарын ажлуудын гүйцэтгэлийн тайлан, цооногийн хэмжилтийн ажлын тайлан, цооногийн засвар үйлчилгээний ажлын тайлан зэргийг хүлээж авсан.		
3.1.9	Газрын тосны ашиглалтын талбайнуудад 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг Уул уурхайн сайдын 2015 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 49 дугаар	Үйл ажиллагааны зардал	Хүлээ авсан тайлангийн тоо хэмжээ	75	35	70	Газрын тосны ашиглалтын талбайнуудын 2023 онд гүйцэтгэсэн ажлын тайланг Уул уурхайн сайдын 2015 оны 3 дугаар сарын 1-ны өдрийн 49 дугаар тушаалаар батлагдсан	100%	90%

	<p>тушаалаар батлагдсан "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавигдах шаардлага" журмын дагуу хянаж, хүлээн авах.</p>						<p>"Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавигдах шаардлага" журмын дагуу хянаж Газрын тос хадгалах савны үл эвдэх сорилын хяналтын тайлан, Петрочайна дачин тамсаг ХХК-ийн 2023 онд гүйцэтгэсэн олборлолтыг нэмэгдүүлэх Т19-52-Х28, Т19-99, Т21-25-1, Т21-36-4 блокын бүтээн байгуулалтын ажлын тайлан, 1-16 ус шахалтын хувиарлахын өөрчлөлт шинэчлэлийн ажлын тайлангууд, Та-2 ОНБ-ын химийн бодисын агуулахын тайлан, Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн олборлолтыг нэмэгдүүлэх бүтээн байгуулалтын</p>		
--	---	--	--	--	--	--	---	--	--

							ажлуудын тайлан, Петро матад ХХК-ийн БХГ-т талбайн 1:500 масштабтай байр зүйн зургийн ажлын тайлан, Дорнод аймаг Матад сумын Эрдэнэбадрах 6-р багийн нутаг дахь БХГ-т Матад ХХ талбайд баригдах газрын тосны олборлолтын барилга байгууламжийн зориулалттай талбайн инженер геологийн судалгааны тайлан, Матад сум ХХ-р талбайд баригдах Цэн тогоруу-1 дан цооногийн олборлолтын түр байгууламжийн зураг төслийг хүлээн аваад байна.		
3.1.1 0	Гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авах нэгтгэх.	Үйл ажиллагааны зардал	Өртөг нөхөгдөх зардлын тайлангийн тоо хэмжээ	14	2024 оны төлөвлөгөө, төсөв батлуулж, үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчд	2024 оны төлөвлөгөө, төсөв батлуулж, үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн өртөг	Гэрээлэгчдийн 2023 оны 4 дүгээр улирлын өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авч нэгтгэв: Ашиглалтын 3 гэрээлэгчийн 4	100%	100%

					ийн өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авч нэгтгэх.	нөхөгдөх зардлын тайланг хүлээн авч нэгтгэх.	талбайд нийт 128.1 сая ам.доллар, хайгуулын 8 гэрээлэгчийн 10 талбайд 23.2 сая ам.долларыг өртөг нөхөгдөх зардлын тайланд тайлагнасныг хүлээн авч нэгтгэв. Нийт дүнгээр 2023 оны хөрөнгө оруулалтын хэмжээ 155.4 сая ам.доллар: үүнээс өртөг нөхөгдөх зардлын хэмжээ 151.2 сая ам.доллар. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэрээлэгчдийн 2024 оны 3 дугаар улирлын өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авч нэгтгэн үзэхэд: Ашиглалтын 3 гэрээлэгчийн 4 талбайд 58.5 сая ам.доллар, хайгуулын 8 гэрээлэгчийн 9 талбайд 9.7 сая		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							<p>ам.доллар, нийт 68.2 сая ам.долларын зардлын өртгийг нөхөхөөр тайлагнасан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. АМГТГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/1515 дугаар тушаалаар газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй гэрээлэгчдийн 2022 он, 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/66 дугаар тушаалаар газрын тосны хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй гэрээлэгчдийн 2023 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайланг анхан шатны</p>		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						<p>баримтад үндэслэн хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгүүдийг байгуулсан.</p> <p>Ажлын хэсгийн хүрээнд: Хяналт, шалгалт хийх тухай 2024 оны 02 дугаар сарын 3/510, 05 дугаар сарын 3/2370 дугаартай албан бичгийг ашиглалтын 3, хайгуулын 12 гэрээлэгчдэд хүргүүлсэн.</p> <p>Хяналт, шалгалтыг дүгнэлтийн төслийг 2024 оны 05 дугаар сарын 3/2048, 3/2202, 10 дугаар сарын 3/4141, 3/4142, 3/4143, 3/4171, 3/4196, 3/4206, 1/4385, 1/4433, 11 дүгээр сарын 3/4626 дугаар албан бичгүүдээр санал авахаар 11 гэрээлэгчдэд хүргүүлсэн.</p> <p>Хяналт шалгалтын дүгнэлтийг гэрээлэгчдийн</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

							саналын хамт 2024 оны 06 дугаар сарын 1/2566, 1/2634, 11 дүгээр сарын 1/4667, 12 дугаар сарын 1/5145 дугаар албан бичгүүдийг УАГ-т хүргүүлсэн.		
3.1.1 1	Гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тооцоонд хяналт, шалгалт хийх, дүгнэлт гаргах.	Үйл ажиллаг ааны зардал	Гаргасан дүгнэлтийн тоо	11	-	14	Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн газрын тосны ашиглалтын Тосон-Уул 19, Тамсаг 21 талбайд батлагдсан төлөвлөгөө төсвийн дагуу 2022 онд гүйцэтгэсэн ажил, өртөг нөхөгдөх зардлын тайланд гүйцэтгэх хяналт, шалгалтыг дуусган, ГТБТЖ- ын 11.6 дахь хэсэгт заасны дагуу гэрээлэгчийн саналыг авахаар Петрочайна Дачин Тамсаг ХХК-д 2024 оны 5 дугаар сарын 3/2048 дугаар албан бичгээр хяналт, шалгалтын дүгнэлтийн	100%	90%

						<p>төслийг хүргүүлсэн. Гэрээлэгч саналаа 2024.06.05-ны өдрийн 24/1-675 дугаар албан бичгээр ирүүлсэн ба хяналт, шалгалтын дүгнэлт-тайланг саналын хамт Үндэсний аудитын газарт АМГТГ-ын 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 1/2634 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Доншен газрын тос /Монгол/ ХХК-ийн газрын тосны ашиглалтын БХГ97 талбайд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу 2022 онд гүйцэтгэсэн ажил, өртөг нөхөгдөх зардалд гүйцэтгэх хяналт шалгалтыг гүйцэтгэж, үр дүнг нэгтгэн тайлан, дүгнэлтэд гэрээлэгчээс санал авахаар АМГТГ-ын 2024 оны 11 дүгээр</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							<p>сарын 3/4626 дугаартай албан бичгээр гэрээлэгчид хүргүүлсэн. Тайлан, дүгнэлтийг гэрээлэгчийн 2024.12.03-ны 311/24 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналын хамт төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн. Хайгуулын 8 гэрээлэгчийн 10 талбайн 2023 оны өртөг нөхөгдөх зардалд гүйцэтгэх хяналт, шалгалт дуусаж, тайлан, дүгнэлт гэрээлэгчдийн саналын хамт АМГТГ-ын 2024 оны 11 дүгээр сарын 1/4667 дугаартай албан бичгээр УАГ-т хүргүүлсэн. 2023 онд гүйцэтгэсэн 2019-2021 оны ӨНЗ-ын хяналт, шалгалтын ажлын үр дүнтэй холбогдуулан Петрочайна Дачин</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							Тамсаг ХХК-д 2024.02.16-ны 3/674, Доншен газрын тос /Монгол/ ХХК-д 2024.02.16-ны 3/675, 2024.04.01- ний 8/1432 дугаар бүхий хууль, журам мөрдөж ажиллах тухай албан бичгүүдийг боловсруулан, хүргүүлж ажиллав. 2024 онд гүйцэтгэсэн 2022 оны ӨНЗ-ын хяналт, шалгалтын ажлын үр дүнтэй холбогдуулан Петрочайна Дачин Тамсаг ХХК-д 2024.06.11-ний 3/2599, Доншен газрын тос /Монгол/ ХХК-д 2024.11.06-ны 3/4625 дугаар бүхий хууль, журам мөрдөж ажиллах тухай албан бичгүүдийг боловсруулан, хүргүүлж ажиллав.		
3.1.1 2	Тосон-Уул XIX, Матад XX, Тамсаг XXI, 1997 оны БХГ-т	Үйл ажиллаг ааны зардал	Батлагдсан менежмент ийн төлөвлөгөө	3	4	4	Петрочайна дачин тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX, Тамсаг XXI	100%	70%

	<p>талбайн 2023 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт тавих.</p>		<p>ний тоо хэмжээ</p>				<p>талбайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 оны 05 дугаар сард БОАЖЯ-аар хянагдан батлагдсан. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөлд тусгагдсан ажлуудыг батлагдсан ажлын төлөвлөгөө, төсөвтэй уялдсан эсэхийг хянасан. Петрочайна дачин тамсаг ХХК нь байгаль орчныг хамгаалах төслийг хийж гүйцэтгэх туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Дорнод аймагт зохион байгуулсан. Уг тендерийн үр дүнтэй холбогдуулан 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 1/2318 дугаар албан</p>		
--	---	--	-----------------------	--	--	--	--	--	--

						<p>бичгээр мэдэгдэл хүргүүлсэн. Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 6.0 га талбайг ургамалжуулж 1,500ш мод тарьсан, тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд кемп орчимд 8,300ш мод тарьж орон нутагт 8,600ш суулгацыг хүлээлгэн өгсөн. Мөн ашиглалтын талбай орчмын малын сэг зэмийг устгал, ариутгал, тостой шороо, лаг цэвэршүүлэх ажлын бэлтгэл ажлыг тус тус хийсэн.</p> <p>Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 оны 04 дүгээр сард батлагдсан. Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн Газрын тос олборлох,</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

						<p>экспортлох төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2023 оны 12 дугаар сард хэлэлцэн батлагдсан. Уг тайлан батлагдсанаар 2024 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн системд оруулах эрх үүссэн бөгөөд одоогоор БОМТ батлагдаагүй БОАЖЯ-д хянагдаж байгаа ба талбайд 10,000ш суулгац тарьсан. Байгаль орчныг хамгаалах, тайлант оны БОМТ-г хэрэгжүүлэхтэй холбогдуулан гэрээлэгчдэд 2024.02.20-ны</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							өдрийн 8/727, 2024.02.20-ны өдрийн 8/728, 2024.03.27-ны өдрийн 8/1395, 2024.04.09-ний өдрийн 3/1593, 2024.05.09-ний өдрийн 8/2093 дугаар албан бичгүүдийг тус тус хүргүүлж ажилласан		
3.1.1 3	Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян, Цагаан-Элсний ордод олборлолтын дэд байгууламж, хуваарилах станц, цооног хоорондын шугам хоолой, цахилгаан дамжуулах шугам, авто зам барих ажилд хяналт тавьж, хамтран ажиллах.	Үйл ажиллаг ааны зардал	Талбайд хяналт тавьж ажилласан хоног	56	18	36	Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайнуудад хийгдэж буй дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлуудад хяналт тавьж ажиллав. Тосон-Уул XIX талбайд газрын тосны олборлолтын 2 цооног, ус шахалтын 6 цооног тэдгээрийн шугам хоолой, цахилгааны холболтыг гүйцэтгэж ашиглалтад шинээр оруулаад байна. Тамсаг XXI талбайд газрын тосны олборлолтын 5	100%	70%

							цооног, Ус шахалтын 8 усны цооног эдгээрийн шугам хоолой, цахилгааны холболтыг гүйцэтгэж ашиглалтад шинээр оруулаад байна. БХГ-т 1997 талбайд ус шахалтын 4 цооног, олборлолтын 16 хуучин цооногийг сэргээж, тэдгээрийн шугам хоолойн угсралт, цахилгааны холболтыг гүйцэтгээд байна.		
3.1.	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх төлбөр урамшуулал, орлогыг тооцож, нэхэмжлэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Орлогын хэмжээ	304.81	361.5	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 57.8 сая ам.долларын тосны экспортын орлого болон 2.0 сая ам.долларын төлбөр, урамшууллыг төвлөрүүлсэн. Засгийн газрын 2018 оны 5 дугаар тогтоолоор	82%	90%	

					баталсан “Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам”-ын дагуу гэрээлэгч компаниудын 2023 оны 12 дугаар сараас 2024 оны 09 дүгээр сард төлсөн нөөц ашигласны төлбөрийн 70 хувийг улсын төсөвт, 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, тусгай зөвшөөрлийн төлбөрийн 70 хувийг улсын төсөвт, 20 хувийг тухайн аймаг, нийслэлийн төсөвт, 10 хувийг сум, дүүргийн төсөвт		
--	--	--	--	--	--	--	--

					<p>хуваарилах тооцоог аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрээр хийж, дүн мэдээг сар бүр Сангийн яаманд 4/109, 1/161, 3/1056, 1/1686, 1/2105, 1/2883, 3/3405, 1/3705, 3/4672 дугаартай албан бичгүүдээр хүргүүлсэн. 2023 оны 12 дугаар сараас 2024 оны 11 дүгээр сард нөөц ашигласны төлбөр нийт 36.5 тэрбум төгрөг төвлөрүүлснэ эс улсын төсөвт 25.5 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд 10.9 тэрбум</p>	
--	--	--	--	--	--	--

						<p>төгрөг, тусгай зөвшөөрлийн төлбөр нийт 2 тэрбум төгрөг төвлөрүүлснэ эс улсын төсөвт 1.3 тэрбум төгрөг, 18 аймгийн төсөвт (давхардсан тоогоор) 417 сая төгрөг, сумын төсөвт 64 (давхардсан тоогоор) 199 сая төгрөг тус тус хуваарилагдсан байна. Газрын тосны борлуулалтын орлогоос хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2024 онд нийт 296 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр байна</p>			
3.1.1	Гэрээлэгчдийн борлуулсан түүхий тосны орлого, зардал, нөөц ашигласны	Үйл ажиллагааны зардлаар	Орлогын хэмжээ	304.81 тэрбум төгрөг	135.5 тэрбум төгрөг	361.5 тэрбум төгрөг	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 57.8 сая ам.долларын тосны экспортын орлого болон 2.0	82%	90%

	<p>төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тос, Монгол Улсын Засгийн газарт ногдох орлогын тайлан тооцоог хүлээн авч, нэгтгэх.</p>						<p>сая ам.долларын төлбөр, урамшууллыг төвлөрүүлсэн. Засгийн газрын 2018 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам”-ын дагуу гэрээлэгч компаниудын 2023 оны 12 дугаар сараас 2024 оны 09 дүгээр сард төлсөн нөөц ашигласны төлбөрийн 70 хувийг улсын төсөвт, 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, тусгай зөвшөөрлийн төлбөрийн 70 хувийг улсын төсөвт, 20 хувийг тухайн аймаг, нийслэлийн төсөвт, 10 хувийг сум, дүүргийн төсөвт хуваарилах тооцоог аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрээр</p>		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						<p>хийж, дүн мэдээг сар бүр Сангийн яаманд 4/109, 1/161, 3/1056, 1/1686, 1/2105, 1/2883, 3/3405, 1/3705, 3/4672 дугаартай албан бичгүүдээр хүргүүлсэн. 2023 оны 12 дугаар сараас 2024 оны 11 дүгээр сард нөөц ашигласны төлбөр нийт 36.5 тэрбум төгрөг төвлөрүүлснээс улсын төсөвт 25.5 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд 10.9 тэрбум төгрөг, тусгай зөвшөөрлийн төлбөр нийт 2 тэрбум төгрөг төвлөрүүлснээс улсын төсөвт 1.3 тэрбум төгрөг, 18 аймгийн төсөвт (давхардсан тоогоор) 417 сая төгрөг, сумын төсөвт 64 (давхардсан тоогоор) 199 сая төгрөг тус тус хуваарилагдсан байна. Газрын</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

							тосны борлуулалтын орлогоос хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2024 онд нийт 296 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр байна		
3.1.2	Гэрээлэгчдийн бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх тусгай зөвшөөрлийн төлбөр, сургалтын урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг төлбөрийг Газрын тосны тухай хууль болон гэрээнд заасан хугацаа, талбайн хэмжээ зэргээс хамааруулан тухай бүр тооцож, нэхэмжлэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах.	Үйл ажиллагааны зардлаар	Төлбөрийн хэмжээ	2.2 тэрбум төгрөг	0.7 тэрбум төгрөг	2.2 тэрбум төгрөг	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төвлөрүүлдэг төлбөр, урамшууллыг тооцож, нэхэмжлэн ажилласан бөгөөд 2024 оны 12 дугаар сарын байдлаар нийт 14 гэрээлэгч нарт албан бичгийг хүргүүлэхэд хяналт тавин ажилласан. Тусгай зөвшөөрлийн төлбөрт 2.0 тэрбум төгрөг, сургалтын урамшуулалд 2.9 тэрбум төгрөг, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг (ТГҮАДТ)-ийн төлбөрт 2.0 тэрбум төгрөг тус	100%	100%

							тус төвлөрүүлсэн.		
--	--	--	--	--	--	--	-------------------	--	--

Үнэлсэн:

.....

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)

Тайлагнасан:

.....

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)

Тамсагийн ордын олборлолт, хадгалалт, тээвэрлэлт хариуцсан мэргэжилтэн, Амгаланбаатар Ёндонсүрэн
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин		Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин			
	1	2	3	4	5	6	7
1.1. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ							
1	Олборлож буй тосны тоо хэмжээнд газар дээр нь хяналт тавих.	Олборлолтын хэмжээ	4.7 сая баррель буюу 645.5 мянган тонн	4.85 сая баррель буюу 659.2 мянган тонн	2024 онд 02.15-2024.02.29, 2024.03.22-2024.04.07, 2024.06.23-2024.07.08, 2024.08.23-2024.09.07, 2024.10.04-2024.10.18, 2024.11.12-11.26-ны хооронд тус тус 6 удаа БХГ-т Тамсаг XXI талбайд албан томилолтоор ажиллаж, олборлож буй тосны тоо, хэмжээнд газар дээр нь хяналт тавин ажилласан. Албан томилолтоор ажиллах хугацаандаа газрын тосны олборлолт, шавхалтын өдөр тутмын мэдээг хүлээн авч, бүртгэл хөтөлж, удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. Тамсаг XXI талбайгаас 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан 315	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 84% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаанд аа гүйцэтгэсэн байдал: 100%

					цооногоос 1,690,180 баррель, задгайгаар буюу цооног шавхалтаар 162,824 баррель, нийт 1,853,004 баррель буюу 255,647 тонн газрын тос олборлосон байна. Тус талбайд олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан нийт 315 цооног байгаа бөгөөд үүнээс нэгдсэн байгууламжид холбогдсон 301 цооног, холбогдоогүй 14 цооногоор хоногт дунджаар 5,254 баррель, задгайгаар буюу цооног шавхалтад ашиглаж буй 93 цооногоор хоногт дунджаар 410 баррель, нийт 5,664 баррель газрын тосыг хоногт олборлож байна. Олборлож буй тосны дундаж нягт 809.9 кг/м3 бөгөөд ордын усны агуулга 69 хувьд хүрсэн байна.аар Хүлээгдэж буй гүйцэтгэлээр Монгол Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4.19 сая баррель буюу 562.6 мянган тонн тос олборлохоор байна.		
